

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
БТСХ	Биеийн тамир, спортын хороо

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Менежментийн захидал.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
СҮЛД БИЕИЙН ТАМИР СПОРТ
ХОРООНЫ ДАРГА Н.БАТСУУРЬ
ТАНАА

2021.02.25 № 07/523
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын Сүлд Биеийн Тамир Спорт Хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын Сүлд Биеийн Тамир Спорт Хорооны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн төлөвлөгөөнд байгуулгын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 7, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 4, нийт 11 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,551,207.91</u>	<u>28,373,701.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	17,551,207.91	28,373,701.00
351	Түүхий эд материал	14,527,148.00	19,882,148.00
35110	Тусгай зориулалттай материал	14,527,148.00	19,882,148.00
354	Хангамжийн материал	3,024,059.91	8,491,553.00
35410	Бичиг хэргийн материал	317,871.43	250,000.00
35420	Аж ахуйн материал	1,285,250.00	6,615,650.00
35450	Барилгын засварын материал	90,000.00	499,200.00
35470	Бусад хангамжийн материал	1,330,938.48	1,126,703.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>347,548,547.61</u>	<u>387,594,603.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	347,548,547.61	387,594,603.28
391	Газар		
392	Биет хөрөнгө	343,985,651.19	384,299,062.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	353,591,500.00	359,418,700.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,643,972.28)	(39,530,744.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,461,286.00	66,901,801.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,931,186.02)	(12,308,785.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,754,823.82	16,652,208.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,246,800.33)	(6,834,115.98)
393	Биет бус хөрөнгө	3,562,896.42	3,295,540.62
39301	Програм хангамж	4,277,692.17	4,277,692.17
39302	Хуримтлагдсан элэгдэл	(714,795.75)	(982,151.55)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>365,099,755.52</u>	<u>415,968,304.28</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>365,099,755.52</u>	<u>415,968,304.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	365,099,755.52	415,968,304.28
512	Хуримтлагдсан үр дүн	365,099,755.52	415,968,304.28
51210	Өмнөх үеийн үр дүн	365,099,755.52	365,099,755.52
51220	Тайлант үеийн үр дүн	-	50,868,548.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>365,099,755.52</u>	<u>415,968,304.28</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	207,941,900.00	514,230,309.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,298,900.00	85,865,409.21
120	Нийтлэг татварын бус орлого	16,298,900.00	85,865,409.21
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	16,298,900.00	85,865,409.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,570,000.00	13,065,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,728,900.00	72,799,709.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,643,000.00	428,364,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	191,643,000.00	428,364,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	191,643,000.00	428,364,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	223,931,162.45	463,361,760.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,931,162.45	463,361,760.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,631,162.45	463,105,643.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,530,400.00	404,690,233.73
210101	Үндсэн цалин	113,662,500.00	244,391,400.00
210102	Нэмэгдэл	54,019,900.00	157,450,833.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,848,000.00	1,848,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,237,965.53	8,749,259.09
210205	Эрүүл мэндийн даатгал	4,237,965.53	8,749,259.09
2104	Хангамж, бараа материалын зардал	5,535,889.56	10,070,706.91
210401	Бичиг хэрэг	702,622.67	474,671.43
210402	Тээвэр, шатахуун	2,432,000.00	2,611,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	143,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,401,266.89	6,842,035.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,949,480.00	10,129,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	212,800.00	16,200.00
210604	Урсгал засвар	2,736,680.00	10,113,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810,000.00	926,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	540,000.00	656,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	270,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,567,427.36	28,539,743.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,685,552.00	1,420,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,881,875.36	27,119,043.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	256,117.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	246,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	10,117.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(15,989,262.45)	50,868,548.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,989,262.45)	50,868,548.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	200,933,165.53	441,420,482.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,570,000.00	13,065,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,570,000.00	13,065,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,570,000.00	13,065,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,570,000.00	13,065,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	190,363,165.53	428,354,782.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,363,165.53	428,354,782.82
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,363,165.53	428,354,782.82
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	200,933,165.53	441,420,482.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,933,165.53	441,420,482.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,633,165.53	441,174,482.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,530,400.00	404,690,233.69
210101	Үндсэн цалин	113,662,500.00	244,391,400.00
210102	Нэмэгдэл	54,019,900.00	157,450,833.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,848,000.00	1,848,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,237,965.53	8,749,259.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,237,965.53	8,749,259.13
2104	Хангамж, бараа материалын зардал	3,342,000.00	5,114,500.00
210401	Бичиг хэрэг	140,000.00	390,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,172,000.00	2,601,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	143,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,030,000.00	1,980,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,982,800.00	14,918,790.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,270,000.00	8,468,590.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	212,800.00	16,200.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	6,434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	950,000.00	926,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	540,000.00	656,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	410,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,590,000.00	6,775,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,590,000.00	6,775,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	246,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	246,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	383,295,852.44	383,295,852.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	383,295,852.44	383,295,852.44
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн		(18,196,096.92)	(18,196,096.92)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	365,099,755.52	365,099,755.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	365,099,755.52	365,099,755.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
D08	Тайлант үеийн үр дүн		50,868,548.76	50,868,548.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	415,968,304.28	415,968,304.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,430,600.00	441,420,482.82	10,117.18	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,430,600.00	441,420,482.82	10,117.18	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,184,600.00	441,174,482.82	10,117.18	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,690,300.00	404,690,233.69	66.31	100.00
210101	Үндсэн цалин	244,391,400.00	244,391,400.00	-	100.00
210102	Нэмэгдэл	157,450,900.00	157,450,833.69	66.31	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,848,000.00	1,848,000.00	-	100.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,749,300.00	8,749,259.13	40.87	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,749,300.00	8,749,259.13	40.87	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,117,100.00	5,114,500.00	2,600.00	99.95
210401	Бичиг хэрэг	390,100.00	390,100.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,601,700.00	2,601,000.00	700.00	99.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	144,900.00	143,000.00	1,900.00	98.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,926,200.00	14,918,790.00	7,410.00	99.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,470,000.00	8,468,590.00	1,410.00	99.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	16,200.00	16,200.00	-	100.00
210604	Урсгал засвар	6,440,000.00	6,434,000.00	6,000.00	99.91
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	926,000.00	926,000.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	656,000.00	656,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	270,000.00	270,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,775,700.00	6,775,700.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,775,700.00	6,775,700.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,000.00	246,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	246,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	246,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,430,600.00	441,420,482.82	10,117.18	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	428,364,900.00	428,354,782.82	10,117.18	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	428,364,900.00	428,354,782.82	10,117.18	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,065,700.00	13,065,700.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,065,700.00	13,065,700.00	-	100.00

ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	42	(29)	323.08
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12	41	(29)	341.66

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга, хурандаа Н.Батсуурь танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд биет бус хөрөнгийн элэгдлийн тооцооны талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Акпар-Аудит” компанийн захирал Х.Баянбай, аудитор Ж.Амаржаргал, Чанарын хяналтын менежер Д.Хишигсүрэн, аудиторын туслах И.Халиунаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ШШГЕГ-ын алба хаагчдын эрүүл чийрэг, бие бялдрын бэлтгэлжилтийн норматив үзүүлэлтийг дээшлүүлэх, олон нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох, спортоор хичээллэх таатай орчинг бүрдүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэж улс, тив, дэлхий, олимпын аваргуудыг төрүүлэхэд Сүлд БТСХ-ны эрхэм зорилго оршино.

ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биеийн тамир спортын үйл ажиллагаа явуулах;
- Олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд амжилттай оролцох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинээр боловсруулж ШШГЕГ-ын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 тоот тушаалаар батлуулан, мөрдөн ажиллаж эхлэсэн байна.
- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль шинээр батлагдсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Системийн хэмжээнд дотоод хяналт шалгалтыг ШШГЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар хариуцдаг боловч 2020 онд тус хорооны санхүү, аж ахйн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 207,941.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,158.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,868.6 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлтөөс болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	17,551.2	28,373.7	10,822.5
Үндсэн хөрөнгө	347,548.5	387,594.6	40,046.1
Нийт хөрөнгө	365,099.7	415,968.3	50,868.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	365,099.7	415,968.3	50,868.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	365,099.7	415,968.3	50,868.6

Бараа материалын дансны үлдэгдэл 28,373.7 мянган төгрөг болж 10,822.5 мянган төгрөгөөр өссөн нь тамирчдын дасгалын хэрэгслүүд болон цахилгаан, дулааны материалууд ШШГЕГ-аас үнэгүй шилжиж ирснээс шалтгаалжээ.

Ашиглалтгүй, хэрэгцээгүй болон хэрэгцээнээс илүү нөөцөлсөн эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 387,594.6 мянган төгрөг болж, 40,046.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн аргаар барьсан төмөр хашааны өртөг 5,827.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөр 61,337.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 415,968.3 мянган төгрөг болж 50,868.6 мянган төгрөгөөр өссөн нь дээрх эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Сүлд БТСХ-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 306,288.4 мянган төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь батлагдсан урсгал зардлын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 240,487.3 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, урсгал засварын зардлууд байна. Энэ нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалаар тус хорооны бүтэц орон тоог шинэчлэн тогтоож, орон тоо, цалин хөлсийг нэмэгдүүлж тогтоосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан, залруулсан зүйл байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 223,659.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 223,659.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 204,705.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 428,364.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/31 дүгээр тушаалаар орон тоог нэмсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 428,364.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 428,364.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 428,354.8 мянган төгрөгийг зарцуулж 10.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 428,354.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь урсгал засварын зардлыг зардлыг 6.0 мянган төгрөгөөр, холбоо, шатахууны зардлыг 4.1 мянган төгрөгөөр бага зэргийн хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 118 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,387.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,227.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,931.9 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансанд 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан тул 1 албан шаардлага хүргүүлж, 3,295.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Татварын тайлангаар илүү төлөлттэй гарсан нь Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй холбоотой байсан ба тус хэлтэс нь 2021 оны 2 дугаар сард багтаан залруулахаар болсон байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3,295.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.8, 262 дугаар зүйлийн 262.1, 262.1.7 дугаар заалтыг тус тус үндэслэн ШШГЕГ-ын даргын 2020 оны А/31 дугаар тушаалаар тус хорооны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Орон тоо шинэчлэгдсэнтэй холбоотой батлагдсан төсөв өмнөх онтой харьцуулахад 2.5 дахин нэмэгдсэн байна.

Дараагийн аудитор залруулсан алдааг дахин давтсан эсэхийг авч үзэх нь зүйтэй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй санхүүгийн программ хангамжийг 16 жил ашиглахаар тогтоож 3,295.5 мянган төгрөгийн элэгдлийн дутуу байгуулсан нь “Биет бус хөрөнгийг түүнийг үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэсэн Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар буюу Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1-р хавсралтын 4.49-т “Биет бус хөрөнгийг түүний үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэсэн заалттай нийцээгүй, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Биет бус хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэлгүй тогтоох

1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн программын үр ашигтай ашиглах хугацааг зөв тооцож (татварын хуульд 2 жил) элэгдүүлэх нь зүйтэй байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бүртгэлийн программ хангамжийн сайжруулалтыг тогтмол хийлгэж, элэгдүүлэх хугацааг засаж, үр ашигтай ашиглах хугацааг зөв тогтооно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	ШШГЕГ-ын Сүлд БТСХ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021-02-19			САГ-2021/146/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	ШШГЕГ-ын Сүлд БТСХороо		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Биет бус хөрөнгийг 16 жилээр ашиглахаар тооцож элдэгдэл байгуулсан	3,295.5	Зөвлөмж өгсөн	ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны Дарга, Ахлах нягтлан бодогч	Н.Батсуурь Э.Бат-эрдэнэ
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	-	Албан шаардлага	ШШГЕГ-ын Сүлд БТСХ-ны Дарга, Ахлах нягтлан бодогч	Н.Батсуурь Э.Бат-эрдэнэ
ДҮН		3,295.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 132/АО160062
С АГ-2021/146/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын "Сүлд" Биеийн тамир спорт хорооны 2020 оны санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах нийт 151 мэдээнээс 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн Ерөнхий Газрын "Сүлд" Биеийн тамир спорт хорооны дарга, хурандаа Н.Батсуурь нягтлан бодогч Э.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"АКПАР-АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭНХЖИН
Х.БАЯНБАЙ

